

### Хөгжлийн хэлэлцүүлэг 3:

## “УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРЛОГЫГ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛД ЗОХИСТОЙ АШИГЛАХ НЬ”

### Товч тайлан

2012-13 онд зохион байгуулагдах Хөгжлийн асуудлаархи цуврал хэлэлцүүлгийн хүрээнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Монгол Улсын Сангийн яамтай хамтран 1 дүгээр сарын 28-нд “Уул уурхайн салбарын орлогыг Монгол улсын хөгжилд зохистой ашиглах нь” сэдэвт 3 дахь хэлэлцүүлэг НҮБ-ын шинэ байранд амжилттай болж өнгөрлөө. Тус уулзалт хэлэлцүүлэгт Монгол Улсын Засгийн газар, олон улсын, иргэний нийгэм, сургалт судалгааны байгууллагууд болон хэвлэл мэдээллийн 100 гаруй төлөөлөгчид оролцов.

Монгол Улсын хөгжилд уул уурхайн нөөц баялаг чухал үүрэг гүйцэтгэдэг. Уул уурхайн салбар нийт экспортын 89 хувь, улсын төсвийн гуравны нэг, улсын ДНБ-ий 22 хувийг тус тус бүрдүүлжээ. Байгалийн нөөц баялаг ихтэй орнуудын хувьд хөгжлийн чиг хандлагыг дорвитой өөрчлөх онцгой боломжийг уул уурхайн салбар нь олгодог. Гэвч улс орнууд тэрхүү боломжоо үр дүнтэй ашиглаж чаддаггүй тохиолдол олон. *Тэгэхээр Монгол Улс аль чиглэлд явах вэ? Уул уурхайн салбарын орлогыг оновчтой удирдан зарцуулахад хөгжлийн өнөөгийн хэрэгцээг хангах болон хойч үедээ хуримтлал үлдээх зэрэг сонголтын тэнцвэрийг хэрхэн хангах вэ?* Зэрэг асуулт энэхүү хэлэлцүүлгийг явуулах үндэслэл болж байна. 2013 онд уул уурхайн томоохон төслүүд шинээр ашиглалтанд орж байгаа учир дээрх асуудал улам ихээр анхаарал татаж байна.

*Хэлэлцүүлгийн тэргүүлэгч гишүүд:* УИХ-ын гишүүн, Төсвийн бодлогын байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн; Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт; Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны дарга асан, доктор Ч.Хашчулуун; Дэлхийн Банкны Монгол дахь Суурин төлөөлөгч хатагтай Корали Геверс болон Эдийн засагч, хэвлэл мэдээллийн төлөөлөгч Д.Жаргалсайхан нар оролцлоо. Тус хэлэлцүүлгийг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн ахлах эдийн засагч, доктор Саураб Синха удирдан явуулав.

Хэлэлцүүлгийг нээж НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн суурин төлөөлөгч хатагтай Сезин Синаноглу үг хэлэхдээ *“Монгол Улсын уул уурхайн хосгүй их нөөц баялаг, түүнээс орж ирэх их хэмжээний орлого нь засгийн газрын хувьд асар их үүрэг хариуцлага ногдуулж байна. Баялгийг түмэн олонд ашигтай хүртээхийн тулд ямар бодлогыг сонгох вэ гэдгийг оновчтой шийдэх нь чухал юм. Үүнд хүний хөгжилд түшиглэсэн тэгш, тогтвортой, хариуцлагатай хуваарилалт тун чухал гэдгийг тэмдэглэлээ”*. Тэрээр цааш нь дурдахдаа уул уурхайн нөөц баялаг хязгаарлагдмал ч түүнээс олох ашиг урт удаан хугацаанд үргэлжилж Монгол улсын ирээдүй хойч үед мэдрэгдэх ёстой, үүний тулд шинэ арга замыг эрэлхийлэх нь зүйтэй гэв.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт нээж үг хэлэхдээ Монгол Улс уул уурхайн орлогоо нэмэгдүүлэх, хойч үедээ тэгш хуваарилах зарчмыг баримталж байгааг онцлон тэмдэглээд засгийн газар уул уурхайн орлогыг Хүний хөгжил сан болон Төсвийн тогтворжуулалтын санд ашиглах төлөвлөгөөтэй байгааг танилцуулсан юм. Тэрээр цааш нь

сүүлийн гурван жил уул уурхайн салбар улсын төсөвт 2.9 их наяд төгрөгийг төвлөрүүлж, нийт төсвийн орлогын дөрөвний нэг хувийг бүрдүүлж байна. Үүнээс гуравны нэг хувийг нь Монгол Улсын нийт хүн амд хишиг хувь хэлбэрээр тарааж үлдсэн хэсгийг төсвийн зардлыг санхүүжүүлэхэд, 335 тэрбум төгрөгийг Төслийн тогтворжуулалтын санд төвлөрүүлсэн байна.

Уул уурхайгаас олох ашгийг зөвхөн өнөө үеийнхэндээ бус ирээдүй хойч үедээ хүртээхийн тулд Монгол Улс гадаадын улс орнууд тэр дундаа Норвеги, Чили болон Арабын хойгийн улс орнуу эдийн засгаа хэрхэн өргөжүүлж, ард иргэдийнхээ аж амьдралыг дээшлүүлж, хамгийн чухал нь одоо бий болгосон баялгаа ирээдүй хойч үедээ үлдээж буй туршлагаас суралцаж байна. Уул уурхайн орлогын зарим хэсгийг ирээдүйд ашиглах талаар хуулийн төслийг хэлэлцүүлэг явагдаж байна. Уул уурхайгаас бусад салбарын жижиг дунд бизнес эрхлэгчдэд татварын хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх талаар асуудал хэлэлцэж байгаа зэргийг цохон тэмдэглэлээ.

Засгийн газрын зүгээс уул уурхайн орлогыг урт хугацааны тогтвортой хөгжилд чиглүүлэх талаар хэлэлцэж зөвшилцөлд хүрэхийн тулд хэд хэдэн хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж байна. Удахгүй болох Монголын эдийн засгийн форумын үеэр ч энэ асуудлыг хөтөлбөрт тусган бүх оролцогч талуудыг хамруулан санал солилцох талаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт мэдээллээ.

Хэлэлцүүлэг болон асуулт хариултын үеэр хэд хэдэн асуудлыг хөндөж байсны дотор хөрөнгө оруулалтыг хэрхэн оновчтой хийх, өнөө болон хойч ирээдүйнхээ хэрэгцээ шаардлагад хэрхэн нийцүүлж хуваарилах, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх нийгмийн салбарын хөрөнгө оруулалтыг хэрхэн оновчтой хослуулах талаар оролцогчид хэлэлцлээ. Уул уурхайн орлогыг үр дүнтэй зохицуулахын тулд дунд хугацааны хөгжлийн стратегийг боловсруулах нь зүйтэй бөгөөд шинээр батлагдсан төсвийн тухай хууль нь Нутгийн хөгжлийн сангаар дамжин орон нутгийн түвшинд илүү их нөөц боломж төвлөрүүлж байна. Төсвийн төвлөрлийг сааруулснаар бодлогын бүх түвшинд нэгдсэн ойлголцолд хүрсний үндсэн дээр шийдвэр гаргах боломж бүрдэнэ гэж найдаж байна.

Эдийн засгийн хөгжлийн яамыг шинээр байгуулсан нь засгийн газрын зүгээс эдийн засгийг зохицуулах томоохон алхам болсон гэж үзсэн бөгөөд тус яам уул уурхайн орлогыг хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөгжлийн стратегийг боловсруулж хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

УИХ-ын гишүүн Ц. Даваасүрэн ард иргэдийн ур чадварыг сайжруулахад чиглэсэн боловсролын салбарын хөрөнгө оруулалт хэрэгтэй байгааг онцолсон юм. Монгол Улс нь залуучууд олонтой орон бөгөөд ажиллах хүчний салбарт болон улсын хөгжилд залуучуудын оролцоо ямар байхаас улсын ирээдүй ихээхэн хамааралтай. Иймээс уул уурхайн орлогоосоо ард иргэдийнхээ, тэр дундаа залуу үеийнхээ боловсрол, ур чадварт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Эрүүл, боловсролтой ард түмэн улсын ирээдүйн хөгжлийн үндэс суурь болох тул мөн эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулах нь зүйтэйг онцоллоо.

Уул уурхайн орлогыг зөв, үр дүнтэй зарцуулахын тулд ил тод, зохистой улс төрийн засаглал, институц бүрдүүлэх шаардлагатай. Институцын тогтолцоо нь аль нэг хувь хүн болон улс төрчөөс хамааралгүй байх ёстой. Уул уурхайн орлогыг зарцуулахад ил тод

байдал, хариуцлага тооцох механизм нь эргээд нийгэмдээ сайнаар нөлөөлнө гэдэг дээр оролцогчид санал нийлж байлаа.

Монгол Улсын эдийн засаг ашигт малтмалын экспортоос, уул уурхайн орлого дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хэт хамааралтай байна. 2008-09 онд дэлхийн зэсийн үнэ огцом буурснаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарсан билээ. Энэ явдал нь нөөц баялаг ихтэй улс орнууд дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамааралтай, өндөр эрсдэл дунд байдгийг харуулсан. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдсанаар Монгол Улс энэ удаад хямралын үед илүү бэлтгэлтэй болсон байна. Нээлттэй хэлэлцүүлгийн үеэр Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэд сайд эдийн засгийг төрөлжүүлэхэд уул уурхайн орлогыг үйлдвэржилтийг хөгжүүлэхэд зарцуулах нь зүйтэй гэдгийг онцолсон.

Мал аж ахуй болон эко аялал жуулчлал Монгол Улсын хөгжлийн томоохон хэсэг болох боломжтой. Уул уурхайн орлогыг уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэхэд зарцуулснаар ажлын байр болон орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад эерэг нөлөөтэй. Олон улсын байгууллагуудын зүгээс Монгол Улсын чадавхийг бэхжүүлэх үүднээс дэлхийн нөөц баялаг ихтэй бусад орнуудын олж авсан туршлагаас хуваалцах боломжтой. Нээлттэй нийгэм форумын зүгээс бодлого, хөтөлбөрийн хяналт шинжилгээний чадавхийг дээшлүүлэх саналыг дэвшүүлсэн. Хяналт шинжилгээ, хөгжлийн үйл явцад иргэний нийгмийн оролцоог сайжруулах шаардлагатайд оролцогчид санал нэгтэй хүлээн зөвшөөрлөө.

Уул уурхайн орлогыг улс орны өнөө болон ирээдүй хойч үед хэрхэн тэгш, тогтвортой, хариуцлагатай байх зарчмыг баримтлан хүртээх талаар хэлэлцэж зөвшилцөлд хүрэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа гэж үзээд бүх оролцогч талууд хөгжлийн хэлэлцүүлгийг цаг үеэ олсон чухал арга хэмжээ болж байна гэж үзсэн юм.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс Хөгжлийн хэлэлцүүлгийг жил бүр тогтмол зохион байгуулах зорилготой байна. Энэ жилийн цувралын хувьд дахин хоёр хэлэлцүүлгийг 2013 оны 3 дугаар сард “Ногоон хөгжлийн үндэсний стратеги” болон “Монгол Улсын хөгжилд залуучуудын оролцоо” сэдвээр зохион байгуулахаар төлөвлөж байна.

*Дэлгэрэнгүй мэдээллийг дараах вебсайтнаас авна уу [www.undp.mn/Dialogues](http://www.undp.mn/Dialogues).*

\*\*\*